



ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

2017.12.15, БААСАН ~ №241 (787)

~ СОЁЛТ ХҮНИЙ ӨГЛӨӨ СОНИН УНШИХААС ЭХЭЛДЭГ ~

ҮНЭ: 1000Т

Газар дээрээ баригддаг “гэнэн” гишүүн байдаггүй

Үндсэн хуулийн цэцийн Их суудлын хуралдаанаас ямар шийдвэр гарахыг л хүлээе. > 2

“Эрдэнэт үйлдвэр” улсад 534 тэрбум төгрөг төвлөрүүлэв

“Үйлдвэрийн дэргэдэх цахилгаан станцыг 48 мВт-аар өргөтгөх ажил дуусаж байгаа” гэв. > 11



■ Хийн хомсдолын улмаас Британи Орос руу хандав

■ Сбербанк, Alibaba хоёр тохиролцож чадсангүй

Ubinfo.mn сайт шилдэгт багтлаа

“Засгийн газрын мэдээ” сонины цахим хуудас Ubinfo.mn нь Монголын мэдээллийн шилдэг сайтуудын тавдугаарт бичигдлээ.

- Gogo.mn
- Xopom.com
- lkon.mn
- Caak.mn
- Ubinfo.mn
- Zалуu.com
- News.mn
- Peak.mn
- Medee.mn
- Dorgio.mn

Эх сурвалж: Alexa.com©

ОНЦЛОХ

УЛС ТӨР

Хэлмэгдэгчдийн хүүхэд болох 400 орчим иргэнд нөхөх олговор олгоно.

Орлогод нийцсэн орон сууцны хөгжүүлэх төслийг НОСК хэрэгжүүлнэ гэв.

Иргэдийн 48 хувь нь аль нэг намыг дэмжихгүй байгаа гэв.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрыг ЭМЯ-ны дэргэд байгууллаа.

НИТХ-ын бүтцийн өөрчлөлтийг Ажлын албанаас эхлүүлж байна.

ЭДИЙН ЗАСАГ

Орон сууцны үнийн индекс өнгөрсөн сард 0.2 хувиар өслөө.

“Aspire Mining” “Нүүрстэй” төслийн олборлолтоо 18 сарын дотор эхлүүлнэ.

Никелийн ханш он гарснаас хойш 10 хувиар өссөн байна.

АНУ бодлогын хүүгээ 0.25 нэгжээр өсгөж, 1.5 хувьд хүргэв.

БНХАУ-ын жижиглэн худалдаа өнгөрсөн сард 10.2 хувиар өсөв

НИЙГЭМ

Зочид буудал барих газраа ашиглахгүй бол буцааж өгөхийг Су.Батболд УБТЗ-аас хүсчээ.

Оройн цагаар үйлчлэх автобусны тоог нэмжээ.

Сүүлийн үеийн барилгуудын 70-80 хувь чанаргүй гэсэн дүгнэлт гарчээ.

Өнөө маргаашдаа ихэнх нутгаар огцом хүйтрэхийг УЦУОШГ-аас сэрэмжлүүлэв.

ДЭЛХИЙ

АНУ-ын засаг захиргаа Пхеньянтай хэлэлцээ хийх боломжгүй гэж мэдэгдэв.

Израйлын онгоцууд Газа дах босогчдын гурван байрлалд цохилт өгчээ.

Женевийн хэлэлцээнд ирсэн Сирийн сөрөг хүчин Б.Асадыг огцрохыг шаардлаа.

Францад 16-гаас доош насны хүүхэд нийгмийн сүлжээ ашиглах журам гаргана.

Америкийн судлаачид Зика вирус сэтгэцэд ээрхэн нөлөөллийг тогтоов.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

2017.12.15



-17° -24°

ЯЛИМГҮЙ ЦАСТАЙ

ЦАГ АГААРЫН ДЭГЭРЖИГҮЙ МЭДЭЭЛИЙГ 8 ДУГААР НҮҮРЭЭС УНШИНА УУ.



Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

Харилцуурын цаадаах нулимс



Харилцуурын цаанаас зориг муутайхан ярьсан тэр охин нийгэмд салхин цэцэг туурахтай адил хурдан тархаж буй ураг төрлийн хүчирхийллийн ноцтой тохиолдлыг илчлэв. Энэ нь хүүхдийн тусламжийн 108 утсанд өдөр бүр ирдэг энгийн дуудлагын нэгэн жишээ. ▶4, 5

Б.Ганбаяр / ЗГМ©

ЭДИЙН ЗАСАГ

Урлагийн ард орлого нуугдана

Г.Байгал @baigalZGM

Сонсох төдийд л далайн зөөлөн давалгааг хөнгөн хэмнэлийн хамт мэдрүүлдэг “Despacito” дууг та нэг удаа ч болов сонссон гэдэгт итгэлтэй байна. Дэлхийн хамгийн олон хэрэглэгчтэй цахим талбарын нэг болох Youtube-д энэ оны эхээр байршсан уг дууг өнгөрсөн сарын байдлаар давхардсан тоогоор нийт 4.5 тэрбум хүн үзэж, сонирхжээ. Ингэснээр Youtube-ийн хамгийн олон хандалттай уран бүтээлийн жагсаалтын нэгд бичигдэж байна. Зөвхөн Youtube ч гэлтгүй дэлхийн хөгжмийн ертөнцөд олны хүртээл болсон цагаасаа эхлэн цахиур хагалж, шинэ, шинэ дээд амжилтуудыг тогтоосон. Энэ дуу

2017 оны турш дэлхий нийтийг сэвшээ салхитай сэтгэл татам Пуэрто Рикогийн хөнгөн агаад уянгалаг хэмнэлд уярааж бас уургалж дөнгөсөн гэхэд хэтрүүлэг болохгүй биз.

Ингээд зогсохгүй Латин Америкийн Пуэрто Рико улсын эдийн засагт ил болон далд хэлбэрээр ээргээр нөлөөлсөн байх юм. Тодруулбал, “Despacito” олон нийтийн хүртээл болсноос хойших 4-5 сарын дараа Пуэрто Рико зорих жуулчдын тоо 2016 оны мөн үетэй харьцуулахад 50 орчим хувиар нэмэгдсэн байна.

Ялангуяа, тус дууны клипний зураг авалт хийсэн хотуудад очих жуулчдын тоо үлэмж хэмжээгээр нэмэгдсэн нь үүний баталгаа.

▶12

Засгийн газрын мэдээ сонины цахим хувилбар улиралд ердөө 5000 төгрөг

UBINFO.MN

ТӨВРГҮЙ ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР ЭНЭГҮҮ QR КОДЫГ УНШУУЛЖ ЦАХИМ ХУВИЛБАРЫГ 5000 ТӨГРӨГ

Хөрөнгө Оруулагч Үндэстэн

Бид ард түмнээ санхүүгийн эрх чөлөөнд хүргэхэд нэг алхам урагшиллаа!

Алхам 2 Хөрөнгө Оруулагч Үндэстэн нээлттэй ХХ болгов. 2017.12.15

2018

Алхам 1 Хөрөнгө Оруулагч Үндэстэн бэлтгүүлэв. 2016.01.09

Ард Санхүүгийн Нэгдэл ХХ Монголын Хөрөнгөийн Бэрж дээр бүртгэгдэж...

ARD САНХҮҮГИЙН НЭГДЭЛ

ARD ДААТГАЛ | ARD КРЕДИТ | ARD ТӨКӨНЛӨГ | ARD ХАВЬ | ARD АЖИРА | ARD ИБЭРЭГЭЙТ

ARD ТЕНГЕР | МОНГОЛ ШУУДАН | ARD BIT | ARD

Хүчтэй. Хамтдаа

| | | | | | | | |
|------------------------------------|--------------------------------|----------------------------|--|---|-----------------------------|-----------------------|-----------------------|
| MSE ALL 1177.31 2.04% | АЛТ 1256.30 0.07% | ЗЭС 6770 0.7% | 10-ЧИНГИС БОНД 98.990 0.08% | 5-ЧИНГИС БОНД 100.15 0.11% | АМ.ДОЛЛАР 2436.29 | ЮАНЬ 368.59 | РУБЛЬ 41.49 |
|------------------------------------|--------------------------------|----------------------------|--|---|-----------------------------|-----------------------|-----------------------|

Сурталчилгаа



ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ҮНДЭСТЭН

Пресс релиз

2017-11-30

Улаанбаатар хот

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ҮНДЭСТНИЙ ХУВЬЦААНЫ АРИЛЖАА НЭЭГДЛЭЭ

Хөрөнгө Оруулагч Үндэстэн (цаашид Үндэстэн гэх) хаалттай хувьцаат компани Санхүүгийн Зохицуулах Хорооны 2017 оны 9 сарын 24-ны хурлын тогтоолоор Жинст Увс нээлттэй хувьцаат компанитай нэгдэж, Монголын Хөрөнгийн Бирж дээр өнөөдөр хувьцааныхаа арилжааг нээлээ.

Монголын Хөрөнгийн Бирж 8 сарын 15-нд Үндэстнийг нээлттэй хувьцаат компани болохыг зөвшөөрсөн билээ. Манай компани өдгөө 900 гаруй үндэсний хөрөнгө оруулагч иргэд, аж ахуйн нэгжийг эгнээндээ нэгтгэж чадсан бөгөөд хоёр жилийн өмнөөс харилцагчдаа үйлчлүүлж буй банк санхүүгийн байгууллагын хувь эзэмшигчид болгох чин эрмэлзлийн дор байгуулагдсан юм.

Хөрөнгө Оруулагч Үндэстэн нь цаашид Ард Санхүүгийн Нэгдэлтэй хамтран Монголын банк санхүүгийн салбарыг дэлхийн цахим хувьсгалд хамруулах зорилготой ажиллаж байна. Манай компани өдгөө Ард Санхүүгийн Нэгдлийн 7 орчим хувийг эзэмшдэг бөгөөд компанийнхаа нэгж хувьцааны дотоод үнэлгээг хоёр жил хүрэхгүй хугацаанд 60 гаруй хувиар өсгөсөн үр дүнг гаргалаа. Цаашдаа Ард Санхүүгийн Нэгдэл нь өөрөө нээлттэй хувьцаат компани болох зорилт тавин ажиллаж байна.

Хөрөнгө Оруулагч Үндэстэн ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Тамир энэ талаар “Бид Монголын хөрөнгийн зах зээлийн түүхэнд анх удаа урвуу нэгдэл буюу Reverse takeover хэлцлийг амжилттай хийж гүйцэтгэлээ. Юуны өмнө бидний хүсэлтийг хүлээн авч, нийт хувьцаа эзэмшигчдийн хүсэн хүлээсэн шийдвэрийг гаргаж, бидний цаашдын зорилгыг дэмжсэн Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Бирж, Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв, Улсын Бүртгэлийн Ерөнхий газрын хамт олонд Үндэстний нэрийн өмнөөс талархал илэрхийлье. Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжлийн хувьд энэ үйл явдал томоохон түлхэц болно гэдэгт итгэлтэй байна” гэлээ.

ТУЗ-ийн дарга Хутагт овогт Чулууны Ганхуяг цохон тэмдэглэхдээ “1991 оноос хойш мөрөөдсөн нэгэн ажил маань өнөөдөр биеллээ оллоо. Би өөрийн байгуулсан компаниа ард иргэддээ нээлттэй зах зээл дээр санал болгохыг мөрөөдөж ирсэн. Хөрөнгө Оруулагч Үндэстэн ХК нээлттэй компани болж, жирийн иргэд санхүүгийн нэгдэл компаниа эзэмших боломжийг олгосон томоохон үйл явдал болж байна. Миний удирдаж байгаа залуу хамт олон уйгагүй зүтгэж байж энэ амжилтыг гаргалаа. Хамт олондоо, хувьцаа эзэмшигчдэдээ, ТУЗ-ийхөндөө чин сэтгэлээсээ баяр хүргэе. Хамгийн гол нь бидэнд итгэл хүлээлгэж, хөрөнгөө өгч ажилласан хувьцаа эзэмшигчдэдээ талархал илэрхийлж, мэхийн ёслоё. Бид олон нийтийн банк санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч компанитай болоход дахиад ганцхан алхам хийнэ. Ард Банк – Зөв Банктай болох ажил шуудрах шатандаа орлоо.”

Хөрөнгө Оруулагч Үндэстэн ХК, Жинст Увс ХК-тай нэгдсэн хувьцааны арилжааны эхлэх үнэ Монголын Хөрөнгийн Биржийн журмын дагуу нэгдэж буй нээлттэй ХК-ийн нэгтгэлийн өмнөх сүүлийн хаалтын ханш буюу 500 төгрөг байна.

Ард Санхүүгийн Нэгдэл ХК нь санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудад хөрөнгө оруулалт хийж, зах зээл дээрх байр суурь, өрсөлдөх чадвар болон үнэ цэнийг нь дээшлүүлэх замаар хувьцаа эзэмшигчдийнхээ хөрөнгийн өгөөжийг өсгөх зорилт тавин ажиллаж буй үндэсний санхүүгийн холдинг компани юм. Манай бүрэлдэхүүнд Монгол Шуудан, Ард Даатгал, Ард Кредит, Ард Секюритиз, Ард Лайф, Ард Актив, Ард Менежмент, Хөрөнгө Оруулагч Үндэстэн, ТэнГэр Системс, Номын Хишиг, КриптоҮндэстэн зэрэг компани багтаж байна. Хөрөнгө Оруулагч Үндэстэн нь Монголын Хөрөнгийн Бирж дээр бүртгэлтэй нээлттэй хувьцаат компани бөгөөд Ард Санхүүгийн Нэгдлийн өмчлөлд бүртгүүлсэн маркетингийн брэнд юм.

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл бидэнтэй холбоо барина уу.

Хаяг: Сүхбаатар дүүрэг, 8 хороо, Ерөнхий сайд Амарын гудамж, Ард Холдингсийн байр, 2 давхар

w3w: цэнэг.эрдэмтэй.өнгөлөх

Шангри-Ла дахь салбарын хаяг: Сүхбаатар дүүрэг, 1 хороо, Олимпын гудамж, 19А-С, Шангри-Ла Худалдааны Төв, 1 давхар **w3w:** хөтөч.лугших.бүтээлчид

Холбоо барих утас: 77078080, 77078181

И-мэйл хаяг: info@investornation.com

Цахим хуудас: investornation.com

Хүчтэй. Хамтдаа

Залуус

Мөнгө бол ердөө мөрөөдөлд хүрэхэд туслах хөдөлгүүр

Г.Оюунтөгс
@oyuntugsZGM

Уран бүтээлч хүний илэрхийлэмж, мэдрэмж нь сэтгэл дотроос нь урган гардаг. Монголын залуучуудын дунд чөлөөт сэтгэлгээ, тэр дундаа гудамжны бүжгийн шинэ хэв маягийг таниулж, өөрийгөө олоход нь тусалж буй бүжигчин Н. Саруултөгстэй уулзаж, ярилцлаа.

-Хамгийн сүүлд "Бүхнээс дээгүүр" кинон дээр ажиллаж, уран бүтээлээ үзэгчдийн хүртээл болгосон. Одоо амарч байна уу, эсвэл шинэ уран бүтээлдээ аль хэдийнэ орчихсон уу?

-Одоогоор "116" бүжгийн студидээ шинээр сонгон шалгаруулж авсан 61 бүжигчин бэлдэж байна. Өмнө нь бид гадаадаас бүжигчин цалинжуулж авчран сургалт зохион байгуулахад ердөө 30, 40 хүрэхгүй бүжигчин цуглах тохиолдлууд цөөнгүй



С.Батсайхан / ЗГМ©

Би-д биш "бид" гэсэн үгэнд анхаардаг

байсан. Гэвч өнөөдөр нөхцөл байдал өөр. Манай студи хамт олон бүжигчин залуусынхаа амьдралын дараагийн замыг нь дөтөлж өгөхийн тулд хичээж, хөдөлмөрлөж байна даа. Гаднын улс орнуудын хэмжээнд хүрэхэд ганц хүн хангалтгүй. Тиймээс нийтээрээ яаж тэр хэмжээнд хүрч чадах вэ гэдэгт анхаарлаа хандуулж, төсөл бичиж, өдөрт доод тал нь 6-9 цагийн бэлтгэл хийж байгаа.

-Удахгүй залуучуудад зориулан "Сэтгэлийн гал 2" лекц тавих гэж байна. Энэ удаа ямар сэдвээр ярих вэ?

-Одоогийн хүүхэд, залуус шинэ зүйл бүтээе, хийе гэсэн сэтгэлтэй байдаг ч харамсалтай нь уур, айдаас хоёрт оюун санаагаараа эзлэгдчихсэн байна. Ямар нэг зүйл хийе, хэлье гэхээр багш, эсвэл эцэг, эхээсээ айдаг, найз нөхдөөсөө ичдэг. Яг үнэндээ хүүхэд, залуусын маань хамгийн том дайсан өөрийг нь хүлээн зөвшөөрөхгүй байгаа бусад биш. Харин өөрөө өөрийгөө хүлээн зөвшөөрөхгүй байгаа өөрөө л байдаг. Тиймээс айдсаа давж чадах юм бол дэлхий дээрх бүх л зүйл боломжтой гэдэгт итгэдэг. Сэтгэлд гал байвал тулганд гал байдаг гэж Монгол ардын үг байдаг шиг залууст үүнийг үнэ цэнийн талаар яриаар байгаа юм. Хүмүүс ихэвчлэн гэр бүл төлөвлөлт, амжилтад хүрэх арга, хүн байх гэсэн тодорхой хэдхэн сэдвээр лекц уншидаг. Гэхдээ үүнийг өмнөх асуудал нь юу вэ гэдгийг ярилгүй орхигдуулдаг юм шиг санагддаг. Хэрэв монгол залуус өсвөр насандаа айдсаа даван туулж, өөртөө итгэлтэй байж чадвал дэлхийн зах зээлд

Монголын бараа бүтээгдэхүүнийг гаргаж ирэх дараагийн саятан байгаа гэж боддог.

-Зарим мэдээллийн сайтад өөрийн тань талаар сөрөг мэдээлэл гарах болсон. Таныг дэмжж байсан залуучууд яагаад нүүрээ буруулах болов?

-Сүүлийн 2-3 сарын хугацаанд намайг чиглэсэн цахим дайралтууд цувран маш хүчтэй явж байгаа. Эхэндээ тоохгүй байсан ч сүүлдээ бүр хувийн амьдрал руу маань ч дайрч, сурдүүлж эхэлсэн. Миний талаарх мэдээнүүдийг болон өгсөн ярилцлагыг маань гэртээ суугаад уншиж байгаа хүмүүст энэ олон үнэн худал нь мэдэгдэхгүй зүйлийг унших хүндээр туссан байх л даа. Гэхдээ ганц зүйл маш сонин санагдсан. Би биш байсан ч хэн нэгэн үнэнийг хэлэхэд өнөөдрийн энэ нөхцөл байдал үүсэж байгаа юм бол бид яг одоо юун дотор амьдарч байгаа юм бэ гэж бодогдсон. "Rapzilla" хэмээх цахим сэтгүүлд өгсөн ярилцлагын хувьд бол улс хоорондын дипломат харилцааны ярилцлага биш л дээ. Зүгээр л Америк, Монгол залуусын хооронд өрсөсөн энгийн яриа байсан. Гэвч хүмүүс ярилцлагад хэт анхаарч, асар их уур цаараар шүүмжлэлтэй хандсан. Одоогийн ийм стресстэй нийгэмд эерэг өөр өнцгөөс харах боломжгүй байгааг ойлгож байна. Гэхдээ энэ бол зөвхөн миний л үзэл бодол шүү дээ. Би өөрийн өнцгөөс харахад бид яг юу хийж чадах вэ гэдгийг л эрэлхийлж байгаа. Хүсэл мөрөөдөлдгүй, зорилгогүй байгаа залуусын сэтгэлгээг яаж өөрчлөх вэ гэдэгт миний санаа зовнидог. Тиймээс миний хэлсэн зүйл монголчуудыгаа муухай харагдуулах үүднээс биш, санаа

Америкийг зорих гол шалтгаан нь тоглолт хийх талбараа тэнд байлгавал илүү боломж байгааг олж харсны.



Хувийн архив©

зовсондоо ярьсан. Яг одоогийн байдлаар хувийн тоглолт гэхээсээ илүү "бид" гэдэг үгэнд анхаарч байна.

-Өнөөдөр бүх зүйл эдийн засаг, бизнес сэтгэлгээтэй болчихсон. Тэгвэл үүнийг өөрчлөх боломжтой гэж харж байна уу?

-Бүх зүйл мөнгөний тухай болсныг ойлгож байгаа. Мэдээж хэрэг гэрээ засчихаад дараагийн асуудалд анхаарах хэрэгтэй л байх. Мөнгө бол ердөө л "хөрөнгө оруулалтын нэг хэлбэр" болохоос мэдэрч байна уу гэдэг л хамгийн чухал. Өөр ямар нэг ашгийн төлөө ажил мэргэжлийг сонгож хийх нь эцэс төгсгөлдгүй морин тойруулга мэт санагддаг. Эцэж цуцаж, та

дуусна уу гэхээс энэ тойруулга өөрөө дуусдаггүй. Гэвч ямар нэг ашгийн төлөө гарч ирээд алдартай болсон хүн буцаад алга болох нь амархан байдаг. Харин удаан хугацаанд нэг зүйлийн төлөө тууштай хөдөлмөрлөж байгаа хүн алдар нэр, амжилт олохоосоо илүүтэй яг тэр хэрээр "ӨВ" гэдэг зүйл үлддэг. Тиймээс бүх зүрх сэтгэлээ зориулж чадах хайртай, дуртай зүйлээ хийж амьдраасай л гэж хэлмээр байна. Мөнгө бол ердөө туслах хөдөлгүүр гэж би боддог.

-Сая хэсэг хугацаанд гадаадад байж бүжгийн тэмцээнд оролцоод ирсэн гэж сонссон?

-Тийм ээ, сая хоёр сарын турш АНУ-д бүжгийн бэлтгэл хийж, сургалтуудад хамрагдаж байгаад ирсэн. Одоохондоо тэмцээнд орно гэхээсээ илүү өөрийгөө бэлдээр л байна. Дэлхийн шилдэг бүжигчдээс очиж зөвлөгөө авч, өөрийн хараагүй өнцгийг олж харан өдөр бүр суралцахад энэ биеэ зориулна гэдэг гайхамшигтай мэдрэмж юм. Аливаа зүйлд өөрийн цаг хугацаа гэж байдаг мэт санагддаг. Цаг нь болохоор дараагийн түвшний тэмцээн уралдаанд оролцох, дэлхийн шилдгүүдтэй хамтарч ажиллах өдөр ирэх байх. Зүгээр л цаг хугацааны асуудал мэт санагдаж

үеийн амбицлах, өөрийнхөөрөө байх хоёрын ялгааг улам тодотгож өгсөн. MILLENIALS буюу гар утас, дижитал ертөнцөд төрж өссөн одоогийн залуусын хувьд зурагтаар л гардаг хүн олны танил байхаа больж байна. Олон дагагчтай байна гэдэг ердөө тэр хүний ертөнцийг үзэх үзэл, зан ааш, амьдралын хэв маягийн л асуудал болж ирсэн. Хамгийн олон дагагчтай хүмүүс хэлбэрээр бус дотоод хүн агуулгаараа бусдыг татдаг болсон.

Ихэнх маань яг үнэндээ төөрсөн чигтээ, амьдрах биш амьд явж байна

Учир нь техник, технологи бидэнд хэзээ ч нэвтэрч чадахгүй гэж бодож байсан тэр хүний дотоод ертөнцийг нээж өгсөн шүү дээ. Би таалагдах гэж хичээх тусам олон дагагчаа алдах нь бичигдээгүй хууль болсон. Өөрийнхөөрөө байх, өөрийнхөө чаддаг зүйлийг хийх нь намайг

зорилго маань том хэмжээний төслийг хөрөнгө оруулалт, бодит зүйл болгох юм. Хэрвээ энэ зүйл биеллээ олбол цаашид Монголын залуусыг өөрийгөө, хүсэл мөрөөдлөө олоход нь туслах видео контент хийх, вэб сайт хээх, гар утасны апп хийх, тогтмол сургалт, лекц зохион байгуулж байх болно. Би өөрөө Hollywood-д очиж бүжиглэх нь Монголын гудамжны бүжгийн хөгжлийг АНУ-ын асар том бүжгийн зах зээлд шууд холбох боломжийг нээж өгнө. Мөн манлайллын чиглэлээр мастер суралцах зорилготой байгаа. Тиймээс ерөнхийдөө өөрийнхөө мөрөөдлийн "Газрын зураг"-ийг тэлэхээр явж байна.

-Урт хугацаа гэхээр яг хэдэн жил гэж тооцож байна вэ. Энэ хугацаанд Монгол дахь ажилтань орхигдохгүй юу?

-Эхний ээлжид хоёр жил болно гэсэн төлөвлөгөөтэй байгаа. Тэгэхдээ АНУ-д очоод юу тохиолдохыг, ямар гайхамшигтай боломжууд гарч ирэхийг мэдэхгүй учраас хэдий хэр хугацааг өнгөрүүлэхийг мэдэхгүй байна. Олон улсын зах зээл дээр гарсан байхад хэзээ ч төсөөлөөгүй боломжууд гарч ирдэг. "116" бүжгийн студи намайг байхгүйд ч үйл ажиллагаа нь зогсолтгүй

бусаас өөр болгодог. Энэ л миний давуу тал. Тэгэхээр миний хариулт бол таны асуултын яг эсрэг. Би од болох гэж, олны танил болох гэж хэзээ ч хичээдэггүй. Ерөө өөрийнхөөрөө л байдаг. Тэгээд л боллоо. Гэхдээ цоо шинэ гэж хэлж болох энэ тогтолцоо дараагийн хэдэн зуундаа технологи дээр суурилсан хүний суурь ойлголт болж төлөвшинэ гэдэгт итгэлтэй байна.

-Удахгүй урт хугацаагаар АНУ-ыг зорих гэж байгаа гэж сонссон. Шинэ уран бүтээлийн үзүүрээс атгасан уу, эсвэл өөр зорилгоор явах гэж байна уу?

-Америкийг зорих гол шалтгаан нь тоглолт хийх талбараа тэнд байлгавал илүү боломж байгааг олж харсанд байгаа юм. Гэхдээ XXI зуунд хаана амьдрах нь сонин биш болсон шүү дээ. Хүсвэл 12 цаг нисээд л хүрээд ирнэ. Гол

явах хэмжээнд хүрсэн. Бүжиглэж байгаа залуус заавал миний сургалтад сууж байж сайжрахгүй. Сүүлийн хоёр жилийн хугацаанд монголд маш олон авьяаслаг бүжигчин гарч ирсэн. Тиймээс өөрсдөө биеэ даагаад, хариуцлага үүрээд явах нь тэдгээр залуусын хөгжих дараагийн том алхам байх болно. Ярилцлагынхаа төгсгөлд хэлэхэд бид хүн болж төрсөн нь дараагийн үеийнхээ өсөж, хөгжих гүүр нь болох явдал гэж боддог. Түүнээс биш унах нүх, бүдрэх чулуу нь болох гэж ирээгүй. Харин өнөөдөр залууст өмнөх үеийнхний анхаарал халамж, хөрөнгө оруулалт асар их дутагдаж байна. Ихэнх маань яг үнэндээ төөрсөн чигтээ амьдрах биш зүгээр л амьд явж байна шүү дээ. Бид тэр залуусыг сэрээж өөрсдийнх нь үнэ цэнийг таниулах хэрэгтэй. [ЗГМ]

ЭВРИКА

Bloomberg TV Mongolia

"Эврика" нэвтрүүлгээр урлагийн ертөнцийн амин сүнс, цохилох зүрх болсон гайхшруулж, оюун бодлыг сорьж, алмайруулж чаддаг гоц авьяастнуудтай уулзуулдаг.

Энэ удаагийн дугаарт Элмгрин ба Драгсет гэж олонд танигдсан Европын уран бүтээлч Майкл Элмгрин, Ингар Драгсет нарыг танилцуулах болно. Өнгөрсөн 20 жилийн турш тэд Техасаас авахуулаад Трафальгарын талбай, Бээжингээс Берлин, Венецийн Биенналияс Нью-Йорк гээд дэлхийн өнцөг булан бүрийн үзэгчдэд санаанд оромгүй бүтээлүүдээрээ бэлэг барьсаар ирсэн юм.

Пүрэв гараг /2017.12.21/

20:30

11:30 Баасан гараг

09:30/20:00 Бямба гараг

16:30/22:30 Ням гараг

ZGM DAILY

Public poll on amendments to the Constitution expected

A total of 327,375 suggestions registered on an online database.

Housing Price Index reported at 0.2 percent

Increase of new housing prices had major impact on the growth.

Tax reform and optimization in Mongolia report released

Scholars conclude different taxes are required to balance the public's living standard.

MSE ALL Index falls by 2.04 percent

MSE market cap stands at around MNT 2.5 trillion.

ZGM: HIGHLIGHTS

POLITICS

Bayartulga Lkhagvasuren, State Secretary of the Ministry of Food, Agriculture and Light Industry, voluntarily dismissed.

Capital City Housing Corporation to implement project on supportive housing development.

A study reports that 48 percent of the public does not support any political party.

General Agency for Health Insurance established under the Ministry of Health.

Sumiyabazar Dolgorsuren, Minister of Mining meets James Anderson, World Bank Country Manager for Mongolia.

ECONOMY

Aspiring Mining LLC to start extraction at "Nuurstei" within 18 months.

Erdenet Mining Corporation collects MNT 534 billion to the State Budget as of November 2017.

Asian Development Bank to provide USD 300 million non-refundable aid on improving the livelihood of farmers sowing vegetables.

SOCIETY

Capital City Public Transportation Authority increases the number of late night buses.

Experts conclude that 70-80 percent of new constructions have poor quality.

Meteorologists warn sharp frost in the following two days.

Artists and performers who have successfully participated in international events and competitions to be granted incentives.

Voters want Cabinet, Parliament separation

Legalizing electoral system.

Prohibiting extra types of expenses and to increase expenditure of the State Budget.

Specifying the President's authority on dismissing the Parliament.

Establishing State Inspection Agency.

Reflecting the establishment of temporary committee for inspections on the constitution.

Setting the duration of the Parliament's regular sessions to be no less than 75 days.

Finalizing a law by the majority of the members present at a session, if not specified by other laws.

Removing the President's authority to initiate a law.

Removing the President's right to give directions related to his/her mandate to the Government.

Limiting the Parliament members to form only one-third of the cabinet appointments.

Around 50 percent of citizens of electoral age participates in poll

Tugsbilig.B
@tugsbiligZGM

A report was disclosed after collecting the suggestions of 327,375 people on the amendments to the Constitution of Mongolia to an online database. According to the report, the public voted to remove the President's rights to initiate a law, dismiss the Parliament, create new types of expense on the State Budget and exercise veto on



Ganbayar.B / ZGM©

Allowing the Prime Minister to assemble /assign, release and dismiss/ the cabinet members.

Allow the Prime Minister to request the Parliament to assemble up to 7 ministers.

Public service to be based on professional, sustainable and progressive advancement principles.

Legalizing the independency and legal basis of Central Bodies of the State's operations.

Prohibiting political discrimination, release and dismissal of public servants on illegal grounds.

Setting the General Council of Courts to consist of eleven members on the Constitution.

Allowing the Parliament to approve Supreme Court Judge and President to approve other judges.

Limiting the minimum age of the Supreme Court Judge at 40 and other judges at 30.

Confirming the administrative territories in the Constitution.

Governors of bag, town and khoro to be appointed directly by the related governors.

Agreed 50.7 percent of the voters disagreed

REAL ESTATE

UB Housing Price rises for the first time in 3 years

Tugsbilig.B
@tugsbiligZGM


General index of housing price rose 0.2 percent compared to the previous month and the same period of last year in November according to the latest report released by Tenkhleg Zuuch LLC. The researchers highlighted

that the increase of new housing prices had major impact on the growth. Average price of new houses was at MNT 2.2 million per square meter in November, showing a bit over 1 percent increase compared to last month. Compared to a year ago, growth was much higher at 6.77 percent.

On the other hand, old housing price index was at 0.92 units showing

a 0.47 percent increase compared to October and 0.5 percent growth year on year.




Housing price index compares the average of Ulaanbaatar's housing price to that of January 2013. Price growth reached its record high of 23.7 percent in March 2014 and has fallen for the last 34 consecutive months. [ZGM]



STOCK MARKET

146,820 shares of 36 firms listed as Tier I, II, and III were traded on Thursday. 10 firms' shares increased in price, 21 decreased and 5 remained unchanged.

The MSE ALL Index decreased by 2.04 percent to 1,177.31 points. The MSE market cap stands at MNT2,489,471,669,340.



RESEARCH

Tax system fails to fulfill its purpose as scholars seek solution



Batsaikhan.S/ ZGM©

At the order of Mongolian National Chamber of Commerce and Industry (MNCCI), scholars and experts from the Business School of National University of Mongolia have released the "Tax reform and optimization in Mongolia" report.

Around 57 percent of the taxpayers who participated in the survey were dissatisfied with the current tax environment, while 28 percent answered the Government should relieve tax pressure and implement effective policies. Accordingly, the experts say that there is a dire need for an independent major research on taxation in Mongolia.

The research, which aims to reform taxation in Mongolia, used both traditional and

modern methods of economic analysis to study and assess the impact of tax on the economy, as well as possibilities for further improvements. As a result, the researchers prepared a guidance on diversifying taxes and optimizing budget revenues and expenditures, which is the main obligation of taxation.

According to a 10-year average, tax revenue accumulated 98.8 percent of the budget revenue, which was mostly formed by taxes. It shows that the tax has fulfilled its obligation to finance the budget; however, it remains disappointing as the current balance has always been on deficit, highlighted the researchers. Furthermore, the scholars reviewed that different

taxes are required to balance the public's living standard. In other words, people with high income should be taxed higher and lower for the low-income. Although private entities benefit from tax deduction and exemption if they employ citizens who lost partial working ability or give donation to disabled persons and non-governmental organizations, the practical results remain unchanged. Because the poverty stood at 30 percent, the minimum living standard was MNT 185.3 thousand and average salary was registered at MNT 861.9 thousand in the last five surveys; thus, the researchers concluded that the tax did not fulfill its role in balancing the public's livelihood. [ZGM]

ZGM: INFOGRAPHIC

MORTGAGE FINANCING

(As of November 2017)



Bank of Mongolia and the Government co-provided



Bank of Mongolia settled

MNT 24.8 billion

financing for the 8 percent mortgage loan program

MNT 15.9 billion

of 237 loaners



Government

132 Loaners

8.9 billion MNT

TOTAL ISSUE OF NOVEMBER

369

loaners received the 8 percent mortgage loan

Оддын дайн: Бодит дүрс, сүрт тулаан

Алдарт цуврал дотроо Star Wars: The Last Jedi сүүлийн үед байгаагүй мундаг нь болжээ. > 10

Умард Солонгост газрын тос экспортлохоо зогсоохыг хүсэв

Бээжин эдийн засгийн харилцаандаа тулгуурлан Пхеньяныг улам шахах ёстой хэмээн Трамп үзэв. > 10

Австралийн төв банк цахим дэвсгэртийн зүг

Төлбөргүй, найдвартай, шуурхай дамжуулдаг нь болоод банкууд криптовалютыг сонирхдог. > 10

Хийн хомсдолын улмаас Британи Орос руу хандав

Дэвид Шеппард

Шинэ жилийн өдрүүдэд Британийн айл өрхүүд АНУ-ын хоригт багтсан Оросын хийгээр халаалт авах болж байна. Умард тэнгисийн хийн хоолой хаагдсаны дараа дотоод хэрэглээг хангахын тулд нийлүүлэлтийн өөр эх сурвалж шаардлагатай болжээ. Ерөнхийлөгч Путин өнгөрсөн долоо хоногт албан ёсоор нээсэн Оросын Арктикийн төслөөс шингэрүүлсэн хий ачсан эхний хөлөг онгоц Британийн Кент муж дахь импортын төвийг чиглэн хөдөллөө. Азид нийлүүлэх ёстой байсан хөргөлттэй ачааны танкер Ямалын ордоос Британийг чиглэсэн нь өрнөдийн хоригийг давж туулсны бэлгэдэл болж, Кремлийг баярлуулах бололтой.

Европ Оросын байгалийн хийнээс хамааралтай хэвээр үлдэнэ гэдэгт Москва итгэлтэй байдаг. Британийн Засгийн газар дөрвөн жилийн өмнөх Украины хэрэг явдлын улмаас Оросын эсрэг авсан хориг арга хэмжээний талаар хатуу байр суурьтай байгаа. Ерөнхий сайд Тереза Мэй саяхнаас шүүмжлэлээ хурцалж, Москва өрнөдийг бусниулахын тул мэдээллийг зөвсөг болголоо хэмээн буруутгасан юм.

30 жилийн настай Умард



BVM©

Ерөнхийлөгч Путинийг төслийн нээлтэд оролцож байх үеэр ачаалсан байгалийн шингэрүүлсэн хий тээвэрлэгч Christophe de Margerie нэртэй танкер энэ сарын 28-нд Британийн эрэгт ирэхээр боллоо.

Дээрх танкерын ачааг Малайзын Petonas компанийн Лондон дахь худалдааны оффис худалдан авсан бөгөөд мөн тайлбар өгөхөөс татгалзав. Британийн албаныхан “Ирж буй байгалийн хийг Британид хэрэглэх эсэх нь зах зээлээс хамаарах хэрэг. Гэхдээ нийлүүлэлтийн олон эх сурвалжтай байх нь бидний хувьд ашигтай” гэжээ. Танкер Норвегийн хойд эргийг даган ирэх хүртэл хоёр долоо хоногийн хугацаа байгаа учир замд нь өөр худалдан авагч илүү үнэ өгвөл чиглэлээ өөрчлөх боломжтой аж. Дотоодын үйлдвэрлэл буурч, хуучин хадгалах байгууламжууд хаагдсан тул Британи өдөр бүр импортоор хий авах шаардлагатай болж байгаа юм.

Wood Mackenzie эрчим хүчний зөвлөх фирмийн шинжээч Фрэнк Харрис саяын жишээ Британи зах зээлд суурилсан хийн импортын загвараас хамаарах болсныг харууллаа гэжээ. Тэрбээр “Энэ загвар ихээхэн уян хатан боловч бусад орнуудтай үнээр өрсөлдөх ёстой болно” хэмээн тайлбарлав. Францын Total компани АНУ-ын санхүүгийн хоригийг үл харгалзан Ямалын төсөл дээр “Новатек”-тэй хамтран ажиллахаар байгаа юм.



тэнгисийн хоолой зогссон нь Британийн хийн хэрэглээний 12 хувийг тасалдуулж, хомсдол үүссэнээр үнэ нь сүүлийн дөрвөн жилийн дээд түвшинд хүрчээ. Түүнчлэн Британийн эрчим хүчний стратеги, нийлүүлэлтийн аюулгүй байдлын талаар асуудал босож ирэв. Британи Европын хоолойгоор дамжуулан Оросоос бага хэмжээний хий импортолж ирсэн. Гэвч ноён Путиний нүдэн дээр ачсан Christophe de Margerie

нэртэй танкер энэ сарын 28-нд Британийн эрэгт ирэхээр боллоо. 2014 онд Крымыг авсны дараа Москвад тавьсан Европын холбоо ба Британийн хориг Ямалын байгалийн хийн ордод шууд хамаарахгүй авч Оросын эрчим хүчний бусад төслүүдийн санхүү, технологийг хязгаарлах зорилготой юм. Оросын Эрчим хүчний яамны нэгэн эх сурвалж Москвагийн эсрэг Британийн хориг нь “Хоол өгч буй гарыг хазсанаас ялгаагүй”

хэмээн зүйрлэв.

Оросын нефть, хийн экспорт хоригт шууд хамрагдаагүй боловч Оросын төслүүдийн санхүүжилтийг тасалдуулахад чиглэсэн АНУ-ын хоригийг давж, товчлосон хугацаандаа нээгдсэн төсөл бол Ямалын шингэрүүлсэн хийн үйлдвэр юм. Уг төслийг хэрэгжүүлсэн “Новатек” компани АНУ-ын Сангийн яамны хар жагсаалтад орж, өрнөдийн санхүүжилтээ алдсан билээ. Тус

компани 27 тэрбум ам.долларын өртөгтэй төслийн санхүүжилтээ еврод шилжүүлж, Хятадаас 12 тэрбум ам.долларын зээл авчээ. “Новатек” үүнд тайлбар өгөхөөс татгалзав. Британийн зохих албад импортын хүчин чадал хангалттай учир өвлийн улиралд нийлүүлэлт тасалдахгүйг мэдэгдээд тус улсад хэрэглэдэг хийн 80 хувь нь дотоодынх гэдгийг онцоллоо. Гэхдээ зах зээлд хандаж, хаанаас импортолохоо шийднэ гэжээ.

Сбербанк, Alibaba хоёр тохиролцож чадсангүй

Макс Седдон

Оросын хамгийн том банк болон Хятадын цахим арилжааны аварга компани хоёр хамтын ажиллагааны талаар жил шахам хэлэлцээ хийсэн боловч тохиролцоонд хүрсэнгүй гэж уг үйл явцыг мэдэх эх сурвалж Financial Times сонинд мэдээлэв. Оросын хадгаламжийн тал хувийг эзэмшдэг Сбербанк ба өнгөрсөн санхүүгийн жилд 547 тэрбум ам.долларын арилжаа хийсэн Alibaba хоёр хамтарч, 140 сая хүн амынх нь талаас илүү нь интернетэд өдөр бүр холбогддог Оросын цахим арилжааны салбарт том өөрчлөлт авчрахаар төлөвлөж байв. Уг түншлэлийн зорилго нь улсын хөрөнгө оруулалттай Сбербанкны үйлчлүүлэгчийн өргөн суурийг Хятадын цахим арилжааны сүлжээтэй холбож, банкны аппликейшнээр дамжуулан бараа борлуулах явдал юм.

Гэтэл талууд хэрхэн хэрэгжүүлэх талаар санал зөрсөн учир хэлэлцээг орхисон гэж эх сурвалж хэллээ. Сбербанк “Бид цуурхалд тайлбар өгөхгүй” гэсэн бол Alibaba

асуултад хариулахаас татгалзав. Сбербанкны ерөнхий захирал Герман Греф Alibaba-г үндэслэгч Жак Матай найз нөхрийн харилцаатай бөгөөд банкаа технологийн салбарт оруулахыг эртнээс сонирхож, дижитал ертөнцөд ажиллаж сурах ёстой гэж үздэг хүн. Тэрбээр тус банк санхүүгийн үйлчилгээний зэрэгцээ цахим арилжаа болон эрүүг мэндийн салбарт хөрөнгө оруулна гэж мэдэгдсэн. Ноён Греф “Орост бизнесийн 50 хувь нь худалдааны салбарт ажилладаг. Цахим худалдаа өргөжихийн хамтаар биет зуучлал тав, зургаан жилийн дотор үеэ өнгөрөөнө” хэмээн ярьжээ.

Гэвч наймдугаар сард Сбербанк Оросын хайлтын Яндекс сүлжээтэй хамтран ажиллахаа зарласан агаад Yandex.Market хэмээх арилжааны сайтыг цахим худалдааны тусдаа компани болгон өөрчлөхийг оролдож байгаа юм. Тус банк шинэ компанийн зах зээлийн үнэлгээ болох нэг тэрбум орчим ам.долларын хагастай тэнцэх хөрөнгө оруулсан байна. Хэ-

лэлцээнд ойр эх сурвалжийн хэлснээр Alibaba-тай хамтарсан компанийн хэн хянах болон үйлчлүүлэгчийнхээ өгөгдлийг ашиглуулахад оронд нь юу хүртэх нь ойлгомжгүй байсан тул ноён Греф Яндекс рүү хандсан аж.

Гэвч өөр нэг эх сурвалжийн ярьснаар Сбербанк Яндекстэй хамтарсан компани байгуулж, хөрөнгө оруулсныхаа дараа уг төсөлдөө Alibaba-г татан оруулахыг хүссэн тул тохиролцож чадаагүй гэнэ. Түүний үгээр Alibaba адил төстэй сайттай хамтран ажиллахыг хүсээгүй байна.

Орос бол Alibaba-гийн хил дамнасан цахим арилжааны салбар болох AliExpress-ийн томоохон зах зээл. Өнгөрсөн онд хоёр талын хил дамнасан цахим худалдаа 37 хувиар өсөж, таван тэрбум ам.долларт хүрсэн нь нийт онлайн зах зээлийн гуравны нэг орчимтой тэнцэнэ. Alibaba Оросын өөр боломжит түншүүдтэй хэлэлцээ хийж эхэлсэн боловч учир утгатай гэрээ байх ёстой гэж уг эх сурвалж хэлсэн юм.



Toyota, Panasonic компаниуд машины зай бүтээхэд хамтарна

Питер Уэлс

Японы хоёр компани цахилгаан машинд зориулсан зай боловсруулахад хамтран ажиллах боломжийг судалж эхэлжээ. Машин үйлдвэрлэгч Toyota болон машины зай үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлэгч Panasonic хоёр цахилгаан машин боловсруулахад түншлэлээ зузаатгах дохио өглөө. Компаниудын захирал Акио Тоёода, Кацухиро Цуга нар ховор тохиолдох хамтарсан хэвлэлийн хурал хийж, дараа үеийн зайн технологийг худалдаанд гаргах ажлыг түргэтгэхэд хамтрахаа зарлав. Уг түншлэл Toyota-д зайн нийлүүлэлтийг найдвартай болгоход туслах юм. Ноён Тоёода 2030 он гэхэд нийт борлуулалтын тэн хагасыг эзлэх гибриッド ба цахилгаан машины тоог 4.5 саяд хүргэнэ гэжээ.

Nissan, Tesla, Volkswagen компаниуд тэргүүлж буй цэвэр цахилгаан машины зах зээлд Toyota харьцангуй сүүлдэж орсон агаад гибриッド болон устөрөгчийн түлшний эсийн технологид анхаарч ирсэн юм. Хэрэв тус компани литий-ион зайнаас илүү чадалтай, хямд, урт эдэлгээтэй

хатуу зай бүтээж чадвал Panasonic салбартаа тэргүүлсэн хэвээр үлдэхэд тус болно. Одоо эднийг Tesla-гийн гол нийлүүлэгч юм. Түүнчлэн цахилгаан машины зай үйлдвэрлэх гол түүхий эд болох литий, кобальт зэргийн нийлүүлэлтэд бэрхшээл тулгарч болзошгүйг энэхүү алхам харуулж байна.

Есдүгээр сард Volkswagen кобальтыг таван жилийн хугацаанд тогтмол үнээр нийлүүлэх тендер зарласан боловч уул уурхайн ямар ч компанитай гэрээ байгуулж чадаагүй. Ноён Тоёода хэлэхдээ машин үйлдвэрлэлийн салбарын үндсэн зорилт нь цахилгаанжуулалт гэдгийг онцлоод Toyota-гийн бензин-цахилгаан вэрлэх боломжгүй гэжээ. Тэрбээр лхагва гарагт Токиод хэлсэн үгэндээ “Японд байгалийн нөөц байхгүй. Их өөрчлөлтийн эрин үеийг туулж гарахын тулд бид зай нийлүүлэлтийг тогтворжуулах үүднээс өрсөлдөх чадвартай зай боловсруулах ёстой. Бид өнөөгийн замаа даган ирээдүйг хүлээж болохгүй” хэмээн тэмдэглэв.

Ноён Цуга хэлэхдээ Panasonic өрсөлдөөнд үлдэхийн тулд


зай үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлэх ёстойг онцлоод “Гэхдээ тэргүүлэгч гэсэн тодорхойлолт цаг хугацаанд өөрчлөгдөх байх” хэмээв. Тэрбээр Tesla-д зориулан хийж буй цилиндр хэлбэртэй литий-нионий цилиндр хэлбэртэй литий-нионий дэлхийд нэгд бичигддэг бүтээгдэхүүн гээд “Хэрвээ ирээдүйг харах юм бол хаана өсөлт гарах вэ. Аль машин үйлдвэрлэгч цахилгаанжуулалтад гол үүрэг гүйцэтгэх вэ. Тэдэнд ямар төрлийн зай шаардлагатай вэ гэх мэтээр өөр асуудлууд тавигдана” хэмээн өгүүлсэн байна.

Хоёр компанийн хамтын ажиллагааны шинэ төлөвлөгөөг Toyota-гийн бензин-цахилгаан хосолмол хөдөлгүүрт машинд зориулсан тэгш өнцөгт зайн нийлүүлэлтийн байдалд суурилан гаргах аж. Түүнчлэн Toyota компани 2020 оноос арилжааны журмаар ашиглаж эхлэх хатуу зайн технологи боловсруулж байгаа талаар мэдээ бий. Лхагва гарагт хамтарсан мэдэгдэл гарахын өмнөхөн Токиогийн бирж дээр Toyota-гийн хувьцааны үнэ 0.6 хувь, Panasonic-ийнх 1.2 хувиар өслөө.



Цахим арилжааны дэлхийн топ 10 зах зээл (2016 онд)

(тэрбум ам.доллар)



© The Financial Times Limited (2015). All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.



Зүйрлэх аваас “Александр Невский”-г өнгөтөөр бүтээчихсэн аятай. Үргэлжлэлийг нь үзмээр байна гэж хэлье. Дараагийн “Оддын дайн”-ыг гаргаад орхи.

Оддын дайн: Бодит дүрс, сүрт тулаан

Найжел Эндрюс

Ер нь гоё болж. Баахан зэрлэг нөхдөд тулхүүлж, дэндүү захын суудалд хажуугийн үзэгч болон, чихрийн цаас, попкорн шажигнах чимээнд ундууцан байж үзсэн ч Star Wars: The Last Jedi кино сайхан болжээ.

Яагаад? Яагаад гэвэл мангаа тэжээдэг тусгай хороо биш, махан бодитой хүн зохиолыг нь бичиж, найруулсан юм. Туульсын бүтээлийн шинэ зохиогч нь Вик триллер, Лоорег зөгнөлт адал явдлын киногоороо нэрд гарсан найруулагч Райан Жонсон. Дахиад бас яагаад? Яагаад гэвэл энэ удаагийн бүтээл сүүлийн хоёр френчайзынх шиг хуучин хэмхэрхий томъёололд баригдалгүй жинхэнэ хүмүүний дүрслэн бодох чадварт тулгуурласан юм.

Анхандаа ойлгомж муутай үйл явдлын товч эхлэл. Босогчдыг удирдаж буй урьдын гүнж, хожмын генерал Лея Органа буюу Кэрри Фишер энэ кинонд хүмүүсийг татах онцгой утга учир болжээ. Харамсалтай нь кинонд бүтэн тоглосон жүжигчин та биднээс хагацаж одсон.

Эрхэм хүндэт Кэрри. Кинонд түүний дүр дуу шуу бага, өдөөгч, өгөөмөр мөртөө ярвагардуу. Тайлбарлах аргагүй илт нэг зүйл бол энэ хүн дэлгэцийг

ээгнэж чадаж байлаа. Тэр энэ кинонд дүр бүтээсний ачаар кино гайхамшигтай болжээ. Кинонд Кэрри өөрийн эрч хүчээ шинээр өндийж буй залуу үеийнхэнд өвлүүлэгчийн дүрээр үлдэж хоцорлоо.

Дан цагаан арьстнууд бүхий сансрын америк драм гэсэн хочноос салдаггүй бүтээлд Финнийн дүрээр Жон Бойега эргэн ирвэ. Харрисон Фордоос өөр хэн ч бүтээж үл чадах Хан Сологийн адилаар тэрбээр үнэнхүү авхаалж самбаатай илд агссан эрийг бүтээж чаджээ.

Орчлон ертөнцийн өөр нэг өнцөгт орших чулуун байшингууд бүхий хад асгат арал дээр Люк Скайуокертэй (Марк Хамилл) Рэй (Дэйзи Ридли) учирна. Хамилл энэ кинонд хуучныг санагдуулсан амгалан байдлаа харуулсан юм. Алс холын дүртэй нэг орон зайд хамт буй мэт яриа хөврүүлэх Рэйгийн тоглолт харин тиймхэн байлаа.

Холограм, график ид шид бүхий дүрс дэлгэцнээ гарахгүй. Камерг хоёр ярилцагч, хоёр өөр арын дэвсгэрийг байгаа чигээр нь таслаад авчихаж.

Шинэчилсэн тууль дахь сансрын байлдаанч эмэгтэйн дүр надад лав нэг л биш санагдав. Дүрийнхээ утга учир, хэл яриаг бүтээх эрэл хийж буй

Ридлигээс ялгаатай нь Адам Драйвер жинхэнэ цогц дүр бүтээжээ. Киноны гол дайсан, “түнэр харанхуйн хүү” Кайло Рэн (Адам Драйвер) эзэнт гүрний сансрын хөлөг дотроо уур хилэнтэй сүүмийнэ. Рэн бол хорсолдоо шаналсан, баргар царайт сахиусан тэнгэр-ад чөтгөр. Сэтгэлийн шаналлаасаа болж хувхай цайсан энэ этгээдийн дотоодод аймшигт албин нуугдаастай нь тодорхой. Энэ этгээд аль талд орох бол? “Оддын дайн”-ы дүрүүд дотор эхнээсээ эцэс хүртэл “Мильтон” (тайлбар: Английн шүлэгч Жон Мильтон) маягийн баатар бол чухам Рэн.

Буудалцаж, дэлбэ үсрэх сансрын хөлгүүд бүхий одот орчлонгийн орон зайн янз бүр үзэгдэл дунд цаг сайхан өнгөрсөн. Бүгд мундаг харагдаж байлаа. Цочирдом лут чимээ чихрийн цаас шаржигнуулагчдын яришгт чимээ дараад л. Сансрын хөлгүүдийг үнэнхүү бүтээлч сэтгэлгээтэй нэгэн урлажээ. Шатаж дэлбэ үсрэх үед хөлгийн их биеийн нарийн хийц Да Винчигийн зөгнөлт таталган зургаас амилаа юу гэлтэй гоё харагдаж байв.

Зохиогч-найруулагч Жонсон ширүүн хурц бүтээл хийж чаддаг хүн. Өнгөлөг, сэтгэл

цочроосон үйл явдлын өрнөл дунд үнэмшилтэй бодит дүр бүтээж чадсан нь хамгаас гол. Экс-гүнж Лея байлдаанд шархдаж гипер нойронд автан түр эзгүйрэх үед удирдлагыг гартаа авсан босогчдын генералд тоглосон Лаура Дерн ч мундаг байлаа. Дерн солиотой этгээд аятай царайгаа үрчилгэн орилж Финнийг, бас По Дамероныг (Оскар Айзек) доромжлон дайрна (Ёстой муухай хүүхэн). Энэ ер нь сайн дүр үү, муу дүр үү?

За тэгээд энэ кинонд гардагчлан мутант, метаморф, криптоморфууд цувж өгнө. Хүмүүн бус амьтдыг та бид өөрсдийн үзэмжээр ойлгох нь зүйтэй тул нэр томъёог нь би бодож олсон юм шүү. Зарим нь ямар учиртайг ойлгох ч юм алга.

Юутай ч туульсын алдарт цуврал дотроо Star Wars: The Last Jedi сүүлийн үед байгаагүй мундаг нь болж. Зүйрлэх аваас “Александр Невский”-г өнгөтөөр бүтээчихсэн аятай. Үргэлжлэлийг нь үзмээр байна гэж хэлье. Дараагийн “Оддын дайн”-ыг гаргаад орхи. Уг туульсын элжит гурамсан цуврал болох учиртай дараагийн гурван бүлгийг бүтээхээр гэрээлчихээд байгаа Райан Жонсонд



Австралийн Төв банк цахим дэвсгэртийн зүг

Эмма Данкли, Элис Вудхаус

Биткойны суурь технологи ашиглан цахим мөнгөн дэвсгэрт бүтээх асуудлыг Австралийн төв банк нухацтай судалж эхэлсэн. Энэ нь голлох төв банкууд дижитал эринд өрсөлдөж буйн сүүлийн жишээ боллоо.

Австрали долларын цахим хэлбэр “eAUD”-ыг уламжлалт мөнгөн дэвсгэртэй зэрэгцүүлэн гаргахын давуу болон сул талыг Австралийн нөөцийн банк (RBA) судалж буйг тус банкны тэргүүн Филип Лоу мэдэгдэв. Лхагва гарагт хуралдсан Австралийн төлбөрийн чуулганы (Australian Payment Summit) үеэр ноён Лоу “Хуваарилалттай данс ашиглан дижитал мөнгөний шинэ хэлбэр гаргах боломж RBA-д байгаа”-г дурдсан юм. Гэхдээ эерэг, сөрөг талыг нь тооцоолж буйтай уялдан дижитал доллар “нэн даруй гаргах төлөвлөгөө” тус банкинд хараахан байхгүйг тэрбээр санууллаа.

Төв банк биткойны суурь болох блокчэйн

буюу хуваарилалттай дансны технологид үндэслэсэн шинэ дижитал доллорын төлбөрийн тогтолцоо үүсгэх бодолтой. Хэрэглэгчийн дижитал хэтэвчинд хадгалагддаг “токен” хэлбэртэй ийм дижитал доллар нь ердийн банкны дэвсгэртэй адил төлбөрийн хэрэгсэл болно.



харьцангуй энгийн болохыг онцлон байж ноён Ллойд “Хэрэгжих нь гарцаагүй зүйл” хэмээн тайлбарласан юм.

Оны эхээр 1000 орчим ам.доллар байсан биткойны үнэ сүүлийн хэдэн долоо хоногт үсрэнгүй өссөөр мягмар гарагт 17428 болсон. Ийм үнэмлэхүй амжилт тогтоосон үед дээрх мэдээ гарчээ. Криптовалютын хөөс үүсэж байна гэсэн түгшүүрийг саяхны үнийн өсөлт улам дэвэргэсэн юм.

Төв болон арилжааны банк, санхүүгийн байгууллагууд санхүүгийн гүйлгээг илүү хямд, ил тод, луйварт өртөхгүйгээр гүйцэтгэхэд хуваарилалттай дансыг хэрхэн ашиглах арга замыг судалцахаар.

Одоогийн банк, төлбөрийн тогтолцоо нь төвлөрсөн цахим данс ашиглан мөнгөний гүйлгээ хийж, хянадаг. Гэвч ийм тогтолцоо ихэвчлэн гар ажиллагаатай, цахим халдлагад эмзэг сул талтай. Харин хуваарилалттай данс нь гүйлгээг тодорхой төвөөр дамжуулалгүйгээр, сүлжээнд холбоотой компьютеруудын

харьцангуй энгийн болохыг онцлон байж ноён Ллойд “Хэрэгжих нь гарцаагүй зүйл” хэмээн тайлбарласан юм. Бэлэн мөнгөний хэрэглээ Австралид буурсаар байгаа нь Скандинавын орнууд зэрэг дэлхийн бусад хэсэгт нийтлэг тохиолдож буй чиг хандлагын тусгал. Австралийн төв банкнаас 2016 онд явуулсан судалгааг үзвэл 2007 онд тус улсын иргэдийн гүйлгээний 70% хувь нь бэлэн мөнгөөр хийгдэж байжээ. Гэтэл энэ үзүүлэлт 2016 онд 37 хувь болж буурчээ.

Биткойны хойноос хөөцөлдөх ухаангүй уралдаан нийт Азийг хамраад байна. Криптовалютын одоогийн үнэ өсөлт нь “цахим төлбөрийн үр дүнтэй хэрэглүүр болж буйг харуулахаасаа илүүтэй явууллага шинжтэй хийрхэлтэй төстэй байгаа”-г ноён Лоу анхааруулав. Уг мөнгө “Хууль бус, далд гүйлгээ хийх хүсэлтэй этгээдүүдийн анхаарлыг л илүү татаж байж болзошгүй”-г тэрбээр нэмж өгүүлсэн юм.



Умард Солонгост газрын тос экспортлохоо зогсоохыг хүсэв

Ким Жон Уныг цөмийн зэвсэг, баллистик пуужингийн хөтөлбөрөөс нь татгалзуулахын тулд Хятад улс Умард Солонгост газрын тос импортлохоо зогсоох нь зүйтэй хэмээн Дональд Трамп үзэж байна. НҮБ-аас тавьсан одоогийн хоригоос илүүг буюу Умард Солонгост газрын тос нийлүүлэхээ зогсоохыг Трампын засаг захиргаа БНХАУ-аас хүсэх бодолтойг АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Рекс Тиллерсон, Үндэсний аюулгүй байдлын зөвлөх Мак Мастер хоёр мягмар гарагт мэдэгдэв. Ийм арга хэмжээ авах нь шоргоолжны дэглэмд эдийн засгийн ноцтой урхагтай.

“Ерөнхийлөгч БНХАУ-ыг газрын тосны нийлүүлэлтээ зогсоогоосой хэмээн хүсэж байгаа”-г ноён Тиллерсон Вашингтон дахь Atlantic Council судалгааны хүрээлэнд үг хэлэх үеэрээ өгүүлсэн юм. “Сүүлд БНХАУ газрын тосны нийлүүлэлтээ зогсооход л Умард Солонгос хэлэлцээ хийхийг зөвшөөрч байв. Нийлүүлэлт зогсооноос гуравхан хоногийн дараа умардууд

ширээний ард суусан” хэмээн Төрийн нарийн бичгийн дарга тайлбарлав.

Хэлэлцээ өрнүүлэх гэвэл Умард Солонгос эхлээд туршилтаа “өөрчлөгдөөгүй”-г ноён Тиллерсон батлан дурдсан юм. БНХАУ нь Умард Солонгостой тогтоосон эдийн засгийн харилцаандаа тулгуурлан Пхеньянд улам шахалт үзүүлэх ёстой хэмээн АНУ үзэж буйг генерал МакМастер тайлбарласан. “НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн шийдвэрт зааснаас ч илүүг хийх

цаг болсныг БНХАУ ойлгоосой. Эдийн засгийн тулах хүч ялангуяа газрын тос, нефтийн бүтээгдэхүүнтэй холбоотой тохиолдолд онцгой утга учиртай” хэмээн тэрбээр анхааруулав.

Дарангуйлагчийг цөмийн хөтөлбөрөөс нь салгахад хүргэх хоёр талын төдийгүй олон талын оролцоот хориг тавих замаар “үнэмлэхүй шахалт” үзүүлэх аргыг Трампын удирдлага доорх АНУ баримталдаг.

Зэвсэгт мөргөлдөөнөөс сэргийлэхийн тулд АНУ-аас гаргаж буй “аварга хүчин чармайлт”-тай зэрэгцүүлэн олон улсын хамтын нийгэмлэг ч Умард Солонгост ахиу дарамт үзүүлэх шаардлагатайг генерал МакМастер тайлбарлав. “Зэвсэгт мөргөлдөөнөөс зайлсхийхийн тулд чадах бүхнээ хийж, дэлхийн бүх улс орон НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн шийдвэрээс хэтэрсэн чармайлт гаргах цаг боллоо” хэмээн генерал уриалж байлаа.

Дарангуйлагч дэглэм сүйрэх тохиолдолд Умард Солонгосын цөмийн зэвсгийг аюулгүй байдалд хамгаалж үлдэх асуудлыг АНУ

БНХАУ-тай ярилцсаныг ноён Тиллерсон дурдсан юм. БНХАУ нь онцгой нөхцөлд ажиллах төлөвлөгөөний талаар АНУ-тай яриа хэлэлцээ өрнүүлэхээс байнга татгалзж ирсэн. Тиймээс энэ нь хоёр улсын харилцаанд чухал ач холбогдолтой үйл явдал боллоо.

Зэвсэгт мөргөлдөөний явцад Умард Солонгосын нутагт нэвтэрсэн АНУ-ын цэрэг хожим нь 38 дугаар параллель руу ухарна гэдгийг ноён Тиллерсон Хятадын талд батлан өгүүлжээ. Дарангуйлагч дэглэм нурах үед нутагт нь цутгах Умард Солонгосын дүрвэгч нараас гадна, АНУ-ын цэргийг хилээс нь алсад байлгаж буй жийргээсээ хагацахаас Бээжин эмээдэг.

Хориг арга хэмжээ Умард Солонгосыг шахаж эхэлж буйг АНУ-ын албаны хүмүүс мэдэгдсэн. Үүний зэрэгцээ АНУ-ын нутагт хүрэх чадвартай цөмийн зэвсэгт пуужин бүтээх Пхеньяны төлөвлөгөө анх таамагласнаас ч ахицтай урагшилж байгаа нь АНУ-ыг түгшүүлэх боллоо. Өнгөрсөн сард Пхеньян АНУ-ын дорнод



BVM©

эргэ хүрэх тусгалтай Hwasong 15 тив хоорондын баллистик пуужингийнхаа гурав дахь туршилтыг хийсэн.

Уг туршилтын дараахан НҮБ дахь АНУ-ын Элчин сайд Никки Хэйли БНХАУ-аас Умард Солонгост газрын тосны хориг тавихыг хүссэнийг мэдээлэлд ойр

сурвалж тайлбарласан юм. Гэтэл АНУ саяхан Умард Солонгосыг терроризм санхүүжүүлэгч улсын жагсаалтад буцаан оруулсан нь утга учир муу, дипломат харилцаанд саадтай арга хэмжээ хэмээн үзсэн Хятадын тал уг саналыг эсэргүүцсэн байна.



Эдийн засаг

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ

АНУ ирэх онд ч бодлогын хүүгээ өсгөнө

Бодлогын хүүгээ 0.25 нэгжээр өсгөж, 1.5 хувьд хүргэлээ

Г.Илч
ЗГМ

АНУ-ын Холбооны нөөцийн банкны Нээлттэй зах зээлийн хороо бодлогын хүүгээ 0.25 нэгжээр өсгөж, 1.5 хувьд хүргэлээ. Ингэснээр он гарсаар тус улс мөнгөний бодлогын жишиг хүүгээ гурав дахь удаагаа өсгөв. Тус улсын эдийн засгийн өсөлт эрчимжиж, хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлт сайжирч буй нь мөнгөний бодлогоо хумих боломж олгож буйг Холбооны нөөцийн банкны бодлого тодорхойлогчид онцолсон байна. Америкийн төв банкны тэргүүн Жанет Йеллен Вашингтонд хийсэн мэдэгдэлдээ тус улсын хөдөлмөрийн зах зээлд шинэ ажлын байр бий болгож, эдийн засгаа дэмжинэ гэдэгт итгэж буйгаа илэрхийлсэн байна.

Тус улсын эдийн засгийн өсөлт нэгдүгээр улиралд саарсан ч сүүлийн хоёр улиралд 3.25 хувьд хүрч, өсөлт нь эрчимжсэн. Ялангуяа, тус улсын өрхийн зарцуулалт тогтвортой түвшинд нэмэгдэж байгаа нь макро эдийн засгийн өсөлтийг дэмжинэ гэж үзэж байна. Мөн бизнесийн салбарт хөрөнгө оруулалт дээ-



BBM©

шилж, олон улсын эдийн засаг таатай нөхцөлд байгаа нь экспортод эерэгээр нөлөөлж буй аж.

Тус улсын татварын бодлого ирэх жилүүдэд эдийн засгийн үйл ажиллагааг тодорхой түвшинд дэмжинэ. Гэхдээ татварын бодлогын макро эдийн засагт үзүүлэх нөлөө тодорхой бус хэвээр байна гэж шийдвэр гаргагчид нь үзэж байна.

Холбооны нөөцийн банкны энэ шийдвэрийн дараа олон улсад ам.долларын ханш чангарч эхэллээ. Тухайлбал, Bloomberg-ээс тооцдог ам.долларын спот индекс гэхэд 0.1 хувиар өссөн

байна. Харин ам.доллартай урвуу хамааралтай алтны ханш буурлаа.

Үүнээс гадна АНУ-ын төв банк тайлан тэнцлийн хэмжээгээ

ирэх сараас сарын 10 тэрбум ам.доллараар бууруулахаар болсон аж. Бодлогын хүүг өсөхөд гол нөлөө үзүүлсэн



ТОМИЛОЛТ

“Эрдэнэт үйлдвэр” улсад 534 тэрбум төгрөг төвлөрүүлэв

Б.Даваатогтох
@datoZGM

Орхон аймагт уул уурхайн салбарынхан цугласан “Хамтын ажиллагаа ба хөрөнгө оруулалт” олон улсын бизнес форум үргэлжилж байна. Уг чуулга уулзалтыг уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэр, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамтай хамтран зохион

байгуулж байна. Энэ үеэр Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар ирэх оны эхний өдрөөс түр хугацаагаар зогсоод байсан хайгуулын тусгай зөвшөөрлийг нийтэд ил болгож, үргэлжлүүлэн олгох чиглэлтэй байгааг дуулгалаа. Тэрбээр чуулганд оролцож буй хөрөнгө оруулагчдад уул уурхайн салбарын тогтвортой бодлогыг Засгийн газар дэмжиж

ажиллана гэдгийг онцлов. Тэрбээр “Өнгөрсөн хугацаанд уул уурхайн салбарын хууль эрх зүйн орчныг 254 удаа шинэчлэх оролдлого хийсэн байна. Энэ нь нэг талаар төр идэвхтэй ажиллаж байгаа мэт харагдавч нөгөө талдаа эрх зүйн орчны тогтвортой байдал алдагдаж байна. Эрх зүйн орчны шинэчлэл хийхдээ гадаад дотоодын хөрөнгө оруулагчдын байр суурийг сонсох ёстой. Уул

уурхайн салбарын хууль эрх зүйн орчныг бага оролдох ёстой. Гэнэтийн шийдвэр гаргахаас татгалзана” гэв.

Мөн тус чуулганаар “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн 2017-2031 оны хөгжлийн үндсэн чиглэлийг танилцуулсан юм. Тус компанийн ерөнхий захирал Х.Бадамсүрэн “2017 он Эрдэнэт үйлдвэрийн хувьд амар байгаагүй. Үйлдвэрийн техникийн технологийг

шинэчлэх ажлыг энэ онд эхлүүлж, бүтээгдэхүүний өртөг зардлыг бууруулахад анхаарч байна. Үйлдвэрийн дэргэдэх цахилгаан станцыг 48 мегаватт-аар өргөтгөх ажил дуусаж байгаа” гэв. “Эрдэнэт үйлдвэр” ХХК энэ оны эхний 11 сарын байдлаар 534 тэрбум төгрөгийг улсад төлжээ. Тус компани оны гүйцэтгэлээр 570 орчим тэрбум төгрөг төсөвт оруулахаар төвлөрсөн байна. [ЗГМ]

ЗГМ: ТОДРУУЛГА

Малчдын 18 орчим хувь нь давхар даатгалд хамрагдсан

Э.Соёл
ЗГМ

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Г.Энхтайванаас малын болон газар тариалангийн давхар даатгалын талаар тодрууллаа.



-Малын индексжүүлсэн даатгалд хэчнээн орх хамрагдаад байна вэ?

-Энэ оны хоёрдугаар сараас зургадугаар сар хүртэл малын индексжүүлсэн даатгалыг хийсэн. Одоогоор 26500 гаруй малчин буюу нийт малчин өрхийн 18 орчим хувь нь хамрагдаад байна. Цаг уурын эрсдэлтэй, зуд их болдог Алтайн нурууны цаад хэсгийн малчид малаа илүү даатгуулж байгаа. Харин Дархан, Сэлэнгэ, Төв зэрэг газар тариалангийн бүсэд энэ хэмжээ харьцангуй бага байна. Энэ онд даатгалд хамрагдсан малчдын тоо өнгөрсөн оноос 22.4 хувиар өссөн.

-Даатгалд цаг агаарын төлөв,

эрсдэлийг хэрхэн тооцдог вэ?

-Манай компани олон улсын давхар даатгалын компаниудтай хамтарч ажилладаг. Дэлхийн байгаль цаг уурын байгууллагаас тухайн бүсийн цаг уурын мэдээллийг урьдчилж аваад тооцоолол хийсний үндсэн дээр манайд үнийн санал ирүүлдэг. Энэ жил тооцоолсноос илүү өнтэй өвөл болох төлөвтэй байна.

-Малын гоц халдварт өвчний эрсдэл энэ даатгалд багтаж байгаа юу?

-Малчдын хувьд шүлхий, мялзан, боом зэрэг малын халдварт өвчин хамгийн ноцтой эрсдэл болдог. Хэдийгээр малын индексжүүлсэн даатгалд бүх эрсдэлийг багтаадаг ч мал нь тухайн сумын хоргогдлын хэмжээнд хүрсэн тохиолдолд өрхөд нөхөн төлбөр олгож эргээс шалтгаалаад хонь, ямааг ихэвчлэн даатгуулдаг. Даатгалын бүтцийг авч үзвэл хамгийн их буюу 61 хувийг ямаа эзэлж байна. Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Увс аймагт Монгол орны ямаан

-Малчид ихэвчлэн ямар мал даатгуулдаг вэ?

-Бод мал зуд, турханд илүү гэсвэртэй. Харин бог мал халдварт өвчинд өртөмтгий зэргээс шалтгаалаад хонь, ямааг ихэвчлэн даатгуулдаг. Даатгалын бүтцийг авч үзвэл хамгийн их буюу 61 хувийг ямаа эзэлж байна. Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Увс аймагт Монгол орны ямаан

сүргийн олонх нь байдаг учраас эдгээр аймгийн малчид түлхүү даатгуулдаг.

-Давхар даатгалыг иргэдэд хэрхэн хүргэж байна вэ. Хураамж нь ямар хэмжээтэй вэ?

-Бид Хаан болон Төрийн банкны орон нутаг дахь салбаруудтай хамтран ажиллаж байгаа. Малчид энэ даатгалд хамрагдсанаар арилжааны банкнаас зээл авахдаа 0.2 хувийн жил дараалан даатгуулах тусгай хувь тухайн бүс нутгийн байгаль, цаг уурын онцлогоос хамаараад 4-6 хувьтай байгаа. Олон малчин даатгуулах тусам нэг малчны төлөх даатгалын хураамж багасна. Өөрөөр хэлбэл, малчид олон жил дараалан даатгуулах тусам хураамж нь багасна гэсэн үг.

-Газар тариалангийн бүсэд давхар даатгал хэрхэн хэрэгжиж байна вэ?

-Монгол орны уур амьсгалын онцлогоос шалтгаалаад газар тариалангийн даатгал маш эрсдэлтэйд тооцогддог. Манай компани тариалангийн даатгал хэрэгжүүлээд хоёр жилийн нүүр үзэж байна. Энэ жил ХХААХҮЯ-наас үрийн тариалалтын тусгай эрх авсан долоон компани манайд даатгуулсан. Үүнээс дөрвөн компанид нийт 230 гаруй сая төгрөгийн нөхөн олговор олгоод байна. [ЗГМ]

ҮЛ ХӨДЛӨХ

Орон сууцны үнийн индекс 0.2 хувиар өсөв


Э.Энх
ЗГМ

“Тэнхлэг зууч” компани орон сууцны үнийн индексийн өөрчлөлтийг танилцууллаа. Энэ оны арваннэгдүгээр сарын байдлаар үнийн индекс өмнөх сараас 0.2 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 0.2 хувиар тус тус өссөн байна. Тухайн сард зах зээлд нийлүүлэгдсэн шинэ болон хуучин орон сууцны үнэ өссөн нь орон сууцны үнийн индекс өсөхөд нөлөөлжээ.

Шинэ орон сууцны нэг м.кв-ын дундаж үнэ нь 2017 оны арваннэгдүгээр сарын байдлаар 2,201,000 төгрөг болж, өмнөх

сараас 1.06 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 6.77 хувиар тус тус өссөн байна. Сүхбаатар дүүрэгт шинэ орон сууцны нэг м.кв-ын дундаж үнэ хамгийн өндөр байгаа бол Сонгино хайрхан дүүрэгт хамгийн бага байна. Харин хуучин хоёр өрөө байрны дундаж үнэ 71.2 сая төгрөг болж, өмнөх сараас 0.89 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 4.17 хувиар тус тус буурлаа.

Орон сууцны үнийн жилийн өсөлт 2014 оны гуравдугаар сард хамгийн өндөр буюу 23.7 хувьтай гарсан юм. 2014 оны арванхоёрдугаар сараас орон сууцны үнэ буурсан ч өдгөө анх тооцож байсан үеийн түвшинд хүрээд байна. [ЗГМ]



ЗГМ ТОВЧХОН

» ТӨСӨВ

73.3

Хувь. Уул уурхайн салбараас энэ онд улсын төсөвт 293.3 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс эхний 10 сарын байдлаар 215.0 тэрбум төгрөг төвлөрүүлж, гүйцэтгэл 73.3 хувьтай байна. Ирэх онд тус салбараас 291.8 тэрбум төгрөгийн орлого улсын төсөвт оруулахаар баталсан юм.

» ТҮҮХИЙ ЭД

0.7

Хувь. Олон улсын зах зээлд алтны ханш 0.1 хувиар буурч, 1254 ам.доллартай тэнцлээ. Харин зэсийн ханш 0.7 хувиар чангарч, 6770 ам.долларыг давлаа.

» ИНФЛЯЦ

ОХУ-ын инфляц арваннэгдүгээр сард түүхэн доод хэмжээнд буюу 2.5 хувьтай гарав. Энэ нь 1991 оноос тооцож эхэлснээс хойших хамгийн доод үзүүлэлт болжээ. Мөн жилийн дундаж инфляцын дүн хамгийн доод хэмжээндээ буюу 2.3 хувьтай гарлаа. Ирэх онд тус улсын инфляцын түвшин ОХУ-ын Төв банкны зорилтот дөрвөн хувиас бага дүнтэй гарах төлөвтэй байна.

» БАЙГАЛИЙН ХИЙ

БНХАУ-ын байгалийн хийн эрэлт ирэх жилүүдэд өсөж, 2040 он гэхэд импорт нь 43 хувьд хүрнэ гэж Олон улсын эрчим хүчний агентлаг (IEA) мэдэгдлээ. Ийнхүү олборлолт нь нэмэгдсэнээр 2040 он гэхэд БНХАУ олон улсын байгалийн хийн худалдааны дөрөвний нэгийг дангаар бүрдүүлэх таамаг гарчээ. Оны эхний найман сарын хугацаанд тус улс нийт 150 тэрбум шоо метр байгалийн хий олборлосноос 37.9 хувийг нь импортлосон байна.

» ДЭЛХИЙ

680

Тэрбум ам.доллар. Европын компаниудын нэгдэн нийлэх хэлцлүүд энэ онд эрчимжиж. Тус бүсийн компаниуд он гарснаас хойш нийт 680 тэрбум ам.долларын хэлцэл хийсэн нь өнгөрсөн оныхоос 23 хувиар өссөн дүн. Эсрэгээрээ АНУ-д энэ тоо 30 хувиар буурч 1.1 их наяд ам.долларт хүрчээ. Харин Азид энэ үзүүлэлт 626 тэрбум ам.доллараар хэмжигдэж байна.

» ГАЗРЫН ТОС

7.06

Сая баррель. Манай улс арванхоёрдугаар сарын 11-ний байдлаар нийт 7.14 сая баррель /968 мянган тонн/ газрын тос олборлож, 7.06 сая баррель /960 мянган тонн/-ийг экспортолжээ. Ингэснээр улсын төсөвт 178.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэв. Газрын тосны экспорт 85.3, төсвийн орлого 93.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

» ТОЛЬ

Спот ханш гэж үнэт цаас, валют, эрдэс бүтээгдэхүүн гэх мэт активуудын спот арилжааны зах зээл дээр тогтож байгаа буюу дилерүүдийн санал болгож буй ханш, үнийг хэлнэ.

ВАЛЮТЫН ХАНШ

| | |
|------------|----------|
| Ам.доллар | 2,436.29 |
| Евро | 2,879.94 |
| Япон иен | 21.61 |
| ОХУ рубль | 41.49 |
| БНХАУ юань | 368.56 |
| БНСУ вон | 2.24 |

Эдийн засаг

БИЗНЕС

Урлагийн ард орлого нуугдана

"Despacito" дуу Пуэрто Риког зорих жуулчдын тоог 50 орчим хувиар өсгөжээ

«1»

Далайн эргийн энэ улсад жилд дунджаар дөрвөн сая орчим жуулчин зочилдог. Тэгвэл ирэх онд жуулчдын тоо зургаан саяд хүрэх төлөвтэйг тус улсын албаныхан нь тооцсон байна.

Ийнхүү Пуэрто Рикогийн дуучин Луиса Фонси, реппер Дэдди Янкигийн уран бүтээл бүхэл бүтэн улсын аялал жуулчлалын салбарт өндөр хэмжээний өсөлт авчирч, олон сая жуулчинг татжээ. Жуулчдын тоо өсөхийн хэрээр түүнийг дагасан хэмжээний валютын урсгал нэмэгдэж, улмаар эдийн засагт нь эерэг нөлөө үзүүлсэн нь дамжиггүй. Цаашлаад ирэх онуудад ч өсгөх төлөвтэй байгаа нь Пуэрто Рико харах олон улсын жуулчдын хандлага хэрхэн өөрчлөгдсөнийг ч давхар илтгэнэ.

Гэхдээ сая дурдсан жишээ бол бодит тоон үзүүлэлт. Үүнээс гадна тав орчим минут үргэлжлэх энэхүү клип Пуэрто Рико хэмээх улсын талаар хэчнээн олон хүний үзэл бодлыг өөрчилж чадсанг бид таашиггүй. Тэр тусмаа, тус улс өр төлбөрөө эргүүлэн төлөх чадваргүй болохоо мэдэгдэж байсан амаргүй үед "Despacito" дэлхийн нийтийн хүртээл болж, олон улсын тавцан дахь нэр хүндийг нь өргөжээ.

Испани хэлээр бичигдсэн энэ дууны түүх урлаг эдийн засагт ямар хэмжээний үр ашиг дагуулж болдгийг харуулсан бодит жишээ. Цаашлаад урлаг орлогын эх үндэс болохын баталгаа юм. "Despacito"-тай ижил жишээ цөөнгүй. Тухайлбал, бүлэг бүрээрээ дэлхий нийтийг байлдан дагуулдаг "Game of Thrones" киноны "King's Landing"-ийн байрладаг Хорватын Дубровникийг зорих жуулчдын тоо хүртэл нэмэгджээ.

Соёл урлаг хэмээх хүн бүхэнд таардаг түлхүүрийг зөв ашиглаж чадвал бүх дэлхийн сонирхол, хүслийг удирдаж болохоор байна. Ингэж чадаж буй улс орон ч цөөн биш. Хамгийн тод жишээ нь бидний сайн мэдэх БНСУ. Солонгосын соёл, урлаг нь өдгөө энэ улсын эдийн засгийн олон салбарын түлхүүр болчихоод байгаа.


● **"Game of Thrones" кино Хорватыг зорих жуулчдын тоог өсгөжээ.**

● **Соёл урлаг хэмээх түлхүүрийг зөв ашиглаж чадвал, бүх дэлхийн сонирхол, хүслийг удирдана.**

● **Өмнөд Солонгос улс 1990 оны сүүлчээс соёлын довтолгоогоо эхлүүлсэн нь өдгөө орлогын давлагааг энэ улсад авчирч байна.**



"Despacito" дууны клипний зураг авалт хийсэн Пуэрто Рикогийн хотуудыг зорих жуулчдын тоо 2016 оны мөн үетэй харьцуулахад 50 орчим хувиар нэмэгдсэн байна.



Аялал жуулчлал, гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэл гээд соёл урлаг даган бизнес нь хөгжин дэвжжээр.

1990 оны сүүл үед эдийн засгийн амаргүй үетэй нүүр тулсан Өмнөд Солонгос улс соёлын довтолгоо эхлүүлсэн нь өдгөө орлогын давлагааг энэ улсад авчирч байна. Соёл, урлагаа

дэлхийн зах зээлд гаргаж эхэлсэн 2000 оноос эхлээд тус улсыг чиглэх жуулчдын тоо нэмэгдсэн байдаг. Ялангуяа, энэ урсгал хүчээ авсан 2010 оны дунд үед гэхэд тус улсыг зорих жуулчдын тоо 50 хувиар өсөж байжээ. БНСУ-ын бодлого тодорхойлогчид эхлээд соёл урлагтаа үлэмж хэмжээний мөнгө зарцуулж, салбараар нь дэмжсэн. Одоо харин тарьсан ургацаа хураан авч, урлагтаа тулгуурлан эдийн засгаа өсгөж байна. Ер нь урлаг бол ургадаг орлого болохыг харуулсан олон жишээ бий. Урлагийн аливаа үзүүлбэр, тоглолтоос олох орлогоос гадна урлагийн нөлөө дагасан эдийн засгийн өгөөжийг хэмжихэд амаргүй.

Их Британид жил бүр тогтмол болдог амьд хөгжмийн наадам, тоглолтууд тус улсад багагүй

хэмжээний орлого авчирдаг байна. Өнгөрсөн онд гэхэд л амьд хөгжмийн наадам, арга хэмжээнд оролцогчдын тоо 30.9 саяд хүрсэн бөгөөд энэ төрлийн арга хэмжээнээс дөрвөн тэрбум фунтын орлого олсон байна. Энэ мэт улс орнууд урлагаа орлого болгосоор.

"Game of Thrones" Хорватын Дубровникийг зорих жуулчдын тоог нэмжээ

Хамгийн гол нь соёл урлагаа дэлхий нийтэд хүргэхэд улс

төр, эдийн засгийн нэр нөлөө чухал биш болохыг дампуурлаа зарласан Пуэрто Рикогийн жишээнээс харчихаж болно. Энэ улс өдгөө эдийн засгийн хүнд үетэй нүүр тулж байгаа төдийгүй нийгэм, улс төрийн нөхцөл байдал нь тогтворгүй, бослого, хөдөлгөөн олонтоо гарч, байгалийн гамшигт ч өртөөд буй. Гэсэн хэдий ч үүнийг нь үл харгалзан тус улсад зорчих хүсэлтэй иргэдийн тоо өссөөр.

Дэлхийн хамгийн алдартай хөгжмийн платформ болох Youtube дээр хандалт ихтэй 10 дууны зургааг испани хэлээр дуулсан уран бүтээл бүрдүүлжээ. Мэдээж энэ нь нэг талаас тухайн бүс нутгийн ард иргэдийн онцлогтой холбоотой байж болох ч үүний цаана урлаг хэмээх нууц хүч нуугдаж байгаа нь дамжиггүй.

Үүнээс үзэхэд, монголчууд бидэнд ч ховорхон соёл урлагаа илүү ашиглах, дэлхийд түгээх боломж нээлттэй байна. Тэр тусмаа хорвоод хосгүй хэмээн үнэлдэг урлаг соёлоороо дамжуулан экспортын орлогоо нэмэгдүүлэх боломж байна. Наанадаж л Монголыг зорих жуулчдын тоог өсгөж, өнөөг хүртэл мөрөөдөл хэвээр байгаа хоёр сая зочин хүлээж авах боломж байна. [ЗГМ]

MSE ALL 2.04 хувиар буурчээ



МХБ-ийн жишиг индекс MSE ALL пүрэв гарагт 2.04 хувиар буурч, 1177.31 нэгжид хүрлээ. Ингэснээр Монголын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2.4 их наяд төгрөгтэй тэнцэж байна. Өчигдрийн байдлаар хөрөнгийн биржийн I, II, III ангиллын 36 компанийн 146 мянган ширхэг хувьцаа арилжсан. Үүнээс 10 компанийн хувьцааны ханш өссөн бол 21-ийнх нь үнэ буурчээ. Мөн таван компанийн хувьцааны ханш

тогтвортой хадгалагдсан байна. Тухайлбал, "Монголын хөгжил үндэсний нэгдэл" компанийн хувьцааны ханш хамгийн өндөр буюу 14.98 хувиар өссөн бол "Увс Чацаргана"-ын үнэт цаасны ханш 15 хувиар уналаа. Мөн Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар 12 ширхэг үнэт цаас 0.8 сая төгрөгөөр арилжлаа. Түүнчлэн хөрөнгийн зах зээлийн ТОП-20 индекс 2.7 хувиар буурлаа. [ЗГМ]

[ЗГМ СОНИН]

ТАНАЙ КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ ЭНД БАЙРЛАЖ БОЛНО

99903584, 99903581

| МОНГОЛД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ ГАДААД КОМПАНИУД | | | | | | |
|---|--------|------|-------|-------|------------|------------|
| НЭР | СИМБОЛ | БИРЖ | ВАЛЮТ | ХАНШ | ӨӨРЧЛӨЛТ % | ОГНОО |
| RIO TINTO | RIO | ASX | AUD | 69.78 | ▼ -0.51% | 12/14/2017 |
| WOLF PETROLEUM | WOF | ASX | AUD | 0.019 | ▼ -5% | 12/14/2017 |
| PETRO MATAD | MATD | LON | GBX | 8.625 | ▼ -6.76% | 12/14/2017 |
| ASPIRE MINING | AKM | ASX | AUD | 0.01 | ▼ -9.09% | 12/14/2017 |
| GUILDFORD COAL | GUF | ASX | AUD | 0.013 | ▼ -7.69% | 12/14/2017 |
| PROPHECY DEVELOPMENT | PCY | TSX | CAD | 4.1 | ▼ -0.49% | 12/14/2017 |
| TURQUOISE HILL RESOURCES | TRQ | TSX | CAD | 3.87 | ▲ +0.26% | 12/14/2017 |
| SOUTHGOBI RESOURCES | SGQ | TSX | CAD | 0.18 | ▼ -2.7% | 12/14/2017 |
| XANADU MINES | XAM | ASX | AUD | 0.67 | ▲ +8.06% | 12/14/2017 |
| ENTREE GOLD | ETG | TSX | CAD | 0.245 | ▼ -5.77% | 12/14/2017 |

| ТҮҮХИЙ ЭД | | | | | | |
|--------------------|--------|---------|-----------|------------|------------|--|
| НЭР | СИМБОЛ | НЭГЖ | ХАНШ (\$) | ӨӨРЧЛӨЛТ % | ОГНОО | |
| АЛТНЫ СПОТ | XAU | унци | 1255.34 | ▼ -0.01% | 12/14/2017 | |
| ЦАГААН АЛТ | PLA | унци | 885.6 | ▲ +1.17% | 12/14/2017 | |
| МӨНГӨ | SIA | унци | 16.08 | ▲ +1.33% | 12/14/2017 | |
| ЗЭС (COMEX) | HGA | фунт | 305.05 | ▼ -0.1% | 12/14/2017 | |
| ТӨМРИЙН ХҮДЭР | TIOA | тонн | 69.34 | ▲ +0.54% | 12/14/2017 | |
| WPI ТОС | CLA | баррель | 56.82 | ▲ +0.39% | 12/14/2017 | |
| БРЕНТ | COA | баррель | 62.93 | ▲ +0.78% | 12/14/2017 | |
| БЕНЗИН | XBA | | 165.74 | ▲ +0.65% | 12/14/2017 | |
| БАЙГАЛИЙН ХИЙ | NGA | Mmbtu | 2.672 | ▼ -1.58% | 12/14/2017 | |
| НҮҮРС (NYMEX) | QZA | тонн | 336.55 | ▲ +0.21% | 12/14/2017 | |
| НҮҮРС (NEW CASTLE) | XWA | тонн | 98.45 | ▲ +0.1% | 12/14/2017 | |
| ЭЛСЭН ЧИХЭР | SBA | фунт | 0.138 | ▲ +0.58% | 12/14/2017 | |
| БУДАА | RRA | центнер | 11.8 | ▲ +0.25% | 12/14/2017 | |
| БУУДАЙ | WA | бушель | 418.25 | ▲ +0.36% | 12/14/2017 | |
| КАКАО | CCA | тонн | 1888 | ▲ +1.12% | 12/14/2017 | |
| КОФЕ | KCA | фунт | 1.201 | ▲ +1.39% | 12/14/2017 | |

Энэхүү ханшийн мэдээлэл нь хүснэгтэд заасан өдрийн 15 цагийн байдлаарх дүн тул үүнээс хойш өөрчлөгдсөн байх боломжтой.



| МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ | | | | |
|-------------------------|--------|-------------|------------|------------|
| НЭР | СИМБОЛ | ХАНШ (нэгж) | ӨӨРЧЛӨЛТ % | ОГНОО |
| АЛУ ХК | APU | 737.13 | ▼ -3.94% | 12.14.2017 |
| ГОВЬ ХК | GOV | 28320 | ▼ -5.35% | 12.14.2017 |
| МАХ ИМПЕКС ХК | MMX | 2900 | ▼ -0.07% | 12.14.2017 |
| МОНГОЛ ШУУДАН ХК | MNP | 608 | ▲ 10.54% | 12.14.2017 |
| ДАРХАН НЭХИЙ ХК | NEH | 21080 | ▲ 6.57% | 12.14.2017 |
| СҮҮ ХК | SUU | 241.89 | ▼ -1.73% | 12.14.2017 |
| ТАЛХ ЧИХЭР ХК | TCK | 32000 | ◄ 0% | 12.14.2017 |
| ТАВАНТОЛГОЙ ХК | TTL | 8980 | ▼ -3.13% | 12.14.2017 |
| АДУУН ЧУЛУУН ХК | ADL | 3361 | ▼ -9.16% | 12.14.2017 |
| БАГАНУУР ХК | BAN | 2116 | ▼ -10.64% | 12.14.2017 |
| БИ ДИ СЕК ХК | BDS | 1253 | ▲ 0.16% | 12.14.2017 |
| БЭРХ УУЛ ХК | BEU | 800 | ◄ 0% | 12.14.2017 |
| УБ-БҮК ХК | BUK | 450 | ▼ -5.58% | 12.14.2017 |
| ДАРХАН ХҮНС ХК | DHU | 5190 | ▲ 7.43% | 12.14.2017 |
| АРИГ ГАЛ ХК | EER | 3900 | ◄ 0% | 12.14.2017 |
| Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК | ETR | 69 | ▼ -2.27% | 12.14.2017 |

Тухайн өдөр арилжаалагдсан хувьцаа

| ДЭЛХИЙН ГОЛЛОХ ИНДЕКСҮҮД | | | | |
|------------------------------|--------|-------------|------------|----------|
| НЭР | СИМБОЛ | ХАНШ (нэгж) | ӨӨРЧЛӨЛТ % | ОГНОО |
| NASDAQ COMPOSITE | CCMP | 6875.801 | +13.48 | ▲ +0.2% |
| DAX INDEX | DAX | 13116.66 | -8.98 | ▼ -0.07% |
| TORONTO STOCK EXCHANGE | SPTSX | 16136.59 | +22.56 | ▲ +0.14% |
| S&P/ASX 200 | AS51 | 6011.259 | -10.57 | ▼ -0.18% |
| S&P 500 | INX | 2662.85 | -1.26 | ▼ -0.05% |
| SHANGHAI COMPOSITE | SHCOMP | 3292.438 | -10.6 | ▼ -0.32% |
| DOW JONES INDUSTRIAL AVERAGE | INDU | 24585.43 | +80.63 | ▲ +0.33% |
| TOP 20 | MSETOP | 21776.06 | -605.17 | ▼ -2.7% |
| FTSE 100 | UKX | 7480.36 | -16.15 | ▼ -0.22% |
| HANG SENG | HSI | 29166.38 | -55.72 | ▼ -0.19% |
| NIKKEI 225 | NKY | 22694.45 | -63.62 | ▼ -0.28% |